

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025.06.18

Мөрөн сум

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаар батлах тухай” А/45 дугаар тушаал, Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/18 дугаар тушаалаар баталсан бүтэц зохион байгуулалтаар нийт 52 орон тоонд багтаан 3 хэлтсийн зохион байгуулалттай, сумын 23 байцаагч, хэлтсийн 22 байцаагч, мэргэжилтэнтэй гүйцэтгэлийн төлөвлөгөө, 5 үйлчилгээний ажилтантай хөдөлмөрийн гэрээ, байгуулан, төсвийн шууд захирагч Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан нийгмийн даатгалын хууль журам хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг ажил олгогч, иргэд даатгуулагчдад хурдан шуурхай хүргэж ажиллаж байна.

ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

Тус газрын Захиргаа хяналтын хэлтэс нь 1 хэлтсийн дарга, газрын 8, 22 сум 1 тосгоны 23 байцаагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, 5 үйлчилгээний ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан нийт 36 хүний бүрэлдэхүүнтэй батлагдсан орон тоогоор ажиллаж байна.

Захиргаа хяналтын хэлтэс нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журам, тушаал, чиглэл, зөвлөмж, баталсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний заалтуудын хэрэгжилтийг хангаж үйл ажиллагаандaa мөрдөж ажилласан.

Нэг.Тэтгэвэр, тэтгэмжийн хяналтын талаар:

2025 оны эхний хагас жилд Жаргалант-56, Цагааннуур-17, Бүрэнтогтох-40, Тариалан-73, Тосонцэнгэл-45, Төмөрбулаг-25, Улаан-Уул-34, Цагаан-Уул-109, Шинэ-Идэр-28, Эрдэнэбулган-38, Ханх-24, Цагаан-Үүр-26, нийт 12 сумын 2024 онд тогтоогдсон 515 тэтгэврийн тогтоолт, олголтыг цахим мэдээллийн сан болон үндсэн баримттай тулган шалгасан. Шалгалтаар 53 тэтгэвэрт баримт материал дутуу бүрдүүлсэн зөрчил илэрснийг шийдвэрлэж ажилласан. Хяналт шалгалтын хугацаанд 3 сумын байцаагчид зөвлөмж хүргүүлсэн. Дотоодын хяналт шалгалтаар нийт 8 тэтгэвэр авагчтай холбоотой 8094.7 мянган төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчил илэрч 7444.7 мянган төгрөгийг барагдуулж, биелэлт 91.9 хувьтай байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт шалгалтын хүрээнд нийт 1621 ажилгүйдлийн

тэтгэмжийн хувийн хэрэгт хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар илүү олгосон 10 даатгуулагчид хамаарах зөрчилд 13,068.1 сая төгрөгийг санд буцаан төлүүлэх акт, тэтгэмжийг дутуу олгосон 18 даатгуулагчид хамаарах зөрчилд 9,303.7 сая төгрөгийг нөхөн олгох, нийт 28 даатгуулагчид хамаарах зөрчилд 22,101.8 сая төгрөгийн акт тогтоож ажилласан байна.

НДЕГ-ын Хяналт шалгалтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн хөнгөлөлттэй нөхцлөөр хууль зөрчиж тэтгэвэр тогтоолгосон 2 тэтгэвэр авагчтай холбоотой 51262.7 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, 7651.0 мянган төгрөгийг барагдуулж, актын барагдуулалт 14.9 хувьтай байна. Акт тогтоогдсон 2 иргэн нь гэрээ байгуулж, хуваарийн дагуу сар бүр төлж байна. Дутуу олгосон 4166.0, илүү олгосон 1272.7 мянган төгрөг төлөгдсөн.

Эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн 24 сумын 2019-2023 онд шинээр тогтоогдсон 6735 тэтгэврийг 2022-2024 онд бүрэн шалгасан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 12 сумын 2024 онд шинээр тогтоогдсон 515 тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгаж, зөрчил дутагдлыг шийдвэрлэж ажилласан. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудад 56 удаагийн сургалт хийж 2099 даатгуулагч иргэд хамрагдсан. Эхний хагас жилийн байдлаар 88 аж ахуйн нэгж байгууллагыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан. Зөрчил дутагдал гаргахгүй ажиллах тал дээр газрын зүгээс онцгой анхаарч тус газрын дарга, хэлтсийн дарга нар болон холбогдох ажилтнууд сумдын байцаагч нарыг арга зүйгээр хангаж 4 удаа цахим сургалт хийсэн. Мөн сумдад шинээр ажилд томилогдсон 4 ажилтныг сурган дадлагажуулах, чадавхжуулах зорилгоор дотоодын сургалтад хамруулсан. Тайлан мэдээг холбогдох дээд газарт хүргүүлж ажиллаж байна.

Хоёр. Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар:

Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу шимтгэлийн авлага өндөртэй болон төлөвлөгөөнд тусгагдсан 88 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг газрын даргын баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэв. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн нийт 87 өргөдөл хүсэлтийг үндэслэн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 21 аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой илэрсэн төлбөр зөрчилд 11610.0 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 11610.0 мянган төгрөгийг барагдуулж, актын биелэлт 100.0%-тай байна.

Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр 16 аж ахуйн нэгж байгууллага, иргэний зөрчилд 6100.0 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. 2025 онд тогтоогдсон нийт актын биелэлт 95.9 хувьтай байна.

төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн дагуу батлагдсан 20 аж ахуйн нэгжээс эхний хагас жилийн байдлаар 10 аж ахуйн нэгжийг хамруулан Зөрчлийн тухай хуулийн дагуу 3 аж ахуйн нэгж байгууллагад 400,0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, 1 аж ахуйн нэгжийн 3 даатгуулагчтай холбоотой 1900.2 мянган төгрөгийн нөхөн төлбөрт акт тогтоож ажиллалаа. Актын барагдуулалт 100 хувьтай байна.

НДЕГ-ын Хяналт шалгалтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн хөнгөлөлттэй нөхцлөөр хууль зөрчиж тэтгэвэр тогтоолгосон 2 тэтгэвэр авагчтай холбоотой 51262.7 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, 7651.0 мянган төгрөгийг барагдуулж, актын барагдуулалт 14.9 хувьтай байна. Акт тогтоогдсон 2 иргэн нь гэрээ байгуулж, хуваарийн дагуу сар бүр төлж байна. Дутуу олгосон 4166.0, илүү олгосон 1272.7 мянган төгрөг төлөгдсөн.

Эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн 24 сумын 2019-2023 онд шинээр тогтоогдсон 6735 тэтгэврийг 2022-2024 онд бүрэн шалгасан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 12 сумын 2024 онд шинээр тогтоогдсон 515 тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгаж, зөрчил дутагдлыг шийдвэрлэж ажилласан. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудад 56 удаагийн сургалт хийж 2099 даатгуулагч иргэд хамрагдсан. Эхний хагас жилийн байдлаар 88 аж ахуйн нэгж байгууллагыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан.

Зөрчил дутагдал гаргахгүй ажиллах тал дээр газрын зүгээс онцгой анхаарч тус газрын дарга, хэлтсийн дарга нар болон холбогдох ажилтнууд сумдын байцаач нарыг арга зүйгээр хангаж 4 удаа цахим сургалт хийсэн. Мөн сумдад шинээр ажилд томилогдсон 4 ажилтныг сурган дадлагажуулах, чадавхжуулах зорилгоор дотоодын сургалтад хамруулсан. Тайллан мэдээг холбогдох дээд газарт хүргүүлж ажиллаж байна.

Тэтгэврийн актын үлдэгдэл 2025 оны 06-р сарын 10-ны байдлаар /1218/ 108586.0 мянган төгрөг, НДЕГазраас тавьсан актын үлдэгдэл 27370.4 мянган төгрөг, Тэтгэмжийн актын үлдэгдэл 19652.8 мянган төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмжийн актын үлдэгдэл 35254.5 мянган төгрөг, ЭМД-ын үлдэгдэл 1165.5 мянган төгрөг, ҮОМШӨТТТ-ын үлдэгдэл 949.7 мянган төгрөг, бусад авлага 6241.5 мянган төгрөг бүгд 199219.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй /1218/ байна. Өмнөх оны үлдэгдэл 2229923.8 мянган төгрөгөөс 23703.9 мянган төгрөгийг, тайлант онд шинээр үүссэн 17839.7 мянган төгрөгийн авлагаас 7444.7 мянган төгрөгийг барагдуулж ажилласан. Нийт 489926.5 мянган төгрөгөөс 324318.2 мянган төгрөгийг барагдуулж, нийт актын биелэлт 66.2 хувьтай байна. Дотоодын хяналт шалгалтын тайланг хагас бүтэн жилээр НДЕГазарт хүргүүлсэн.

Гурав. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

Тайлант хугацаанд иргэд, байгууллагаас сайн дурын даатгалын запруулга хийх хүсэлт 118, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх хүсэлт 87, тэтгэвэр дахин хянуулах хүсэлт 44, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд 98, бусад шалтгаанаар 84 нийт 431 өргөдөл гомдол хүлээн авч хуулийн хугацаанд 418 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 13 өргөдөл

байна. Шийдвэрлэлт 96,9 хувьтай. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу иргэдээс тэтгэвэр тогтоолгох хүсэлт 1310, тэтгэвэр өөрчлөх хүсэлт 344, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэмж тогтоолгох хүсэлт 2786, нийт 4871 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Үүнээс 16 тэтгэвэр, тэтгэмжийн өргөдөл хуулийн үндэслэл хангахгүй шалтгааны улмаас буцаагдсан. Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах төвд иргэд даатгуулагчаас 14, НДЕГ-ын "Иргэд олон нийттэй харилцах 311131 утсанд 48, нийт 62 өргөдөл гомдол гаргасан. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлт 100%, Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 98.4 хувьтай байна.

Дөрөв. Дотоод ажлын чиглэлээр:

Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм журам, тушаал, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зохион байгуулж ажиллалаа. Дээд газраас хүргүүлсэн журам заавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар газрын болон сумдын байцаагч нарт танхимаар 3, цахимаар 8, нийт 11 удаагийн сургалт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 28 дүрэм, журам, заавар, зөвлөмж, чиглэл, албан бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан байна. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 221 дүгээр тогтоолын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 22193 тэтгэвэр авагчийн тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан Засгийн газрын тогтоол 1, ГБХНХЯ-ны сайдын тушаал 1, албан даалгавар 2, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 2, НДЕГ-ын даргын албан даалгавар 2, үүрэг даалгавар 1, холбогдох тушаал 6, чиглэл 7, зөвлөмж 8, заавар 2, нийт 32 албан бичгийн хэрэгжилтийг хангаж ажилласан. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, үүрэг даалгаврын 12 биелэлтийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм журам, тушаал, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зохион байгуулж ажиллалаа. Дээд газраас хүргүүлсэн журам заавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар газрын болон сумдын байцаагч нарт танхимаар 3, цахимаар 8, нийт 11 удаагийн сургалт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 28 дүрэм, журам, заавар, зөвлөмж, чиглэл, албан бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан байна.

Захиргаа, хяналтын хэлтсээс эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 удаагийн сургалтыг газрын нийт 43 албан хаагчдад хийсэн. Тус газрын дотоод орчныг тохижуулах чиглэлд бүх өрөө тасалгааны хаяг, самбарыг шинэчилж, үйлчилгээний зааланд "Үйлчлүүлэгчийн булан"-г өөрчлөн тохижуулж, иргэдийн ая

тухтай байдлыг бий болгох зорилгоор сандал, ширээ, буйдан зэрэг тавилга хэрэгсэл байршуулсан. Нийгмийн даатгалын газрын Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн нь Нийгмийн даатгалын ач холбогдол, хууль, эрх зүйн өөрчлөлтийн талаар аж ахуй нэгж байгууллага, иргэд даатгуулагчдад мэдээ мэдээллийг Podcast хэлбэрээр 2, Live хэлбэрээр 5 удаа, Reel хэлбэрээр 6 удаа хийж нийт хандалтын тоо 13441 хурсэн байна. Сошиал сурталчилгааны энэхүү төрлийг 2024 онд шинэлэг ажил болгож хүрээг өргөжүүлэн ажиллах телевлөгөө гаргаж ажилласан.

Ажил олгогч, иргэд даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

1. Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг:

- Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт
- Албан хаагчдын үйлчилгээний чанар хүртээмж,
- Нийгмийн даатгалын газрын албан хаагчдын ёс зүй,
- Тус газрын сургалт сурталчилгаа,
- Нийгмийн даатгалын газраас хүргэж байгаа мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдал,
- Portal.ndaatgal.mn сайтын ашиглалт гэсэн 7 асуултын хүрээнд, маш сайн, сайн дунд, муу, хангалтгүй гэсэн асуулгаар сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Судалгаанд нийт 45 ажил олгогч хамрагдсан. Үүнээс: Маш сайн гэсэн асуулгыг сонгосон 51 буюу 16 хувь, сайн гэсэн асуулгыг 164 буюу 52 хувь, дунд гэсэн асуулгыг сонгосон 91 буюу 29 хувь, муу гэсэн асуулгыг сонгосон 6 буюу 2 хувь, хангалтгүй гэсэн асуулгыг сонгосон 3 буюу 1 хувийг тус тус эзлэж байна. Судалгаанд оролцогчдын 68 хувь нь тус газрын ажил үйлчилгээг маш сайн, сайн гэж дүгнэсэн бол 29 хувь нь дунд, 5 хувь нь муу, хангалтгүй гэж дүгнэсэн байна.

2. Даатгуулагчийн сэтгэл ханамжийн судалгааг:

- Нийгмийн даатгалын газрын чанар хүртээмж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, албан хаагчдын үйлчилгээний шуурхай байдал, ёс зүй харилцаа хандлага, нээлттэй утасны үйлчилгээ, мэдээллийн ил тод байдал, нийгмийн даатгалын шимтгэл төлөх ач холбогдол гэсэн 7 асуулгын хүрээнд судалгаа авлаа. Судалгаанд нийт 37 даатгуулагч хамрагдсан. Үүнээс маш сайн 97 буюу 38.3 хувь, сайн 88 буюу 34.4, дунд 43 буюу 16.8 хувь, муу 16 буюу 6.3 хувь, хангалтгүй 11 буюу 4.3 хувийг тус тус эзэлж байна. Судалгаанд оролцсон иргэдийн 72.7 хувь нь тус газрын ажил үйлчилгээг маш сайн, сайн гэж дүгнэсэн байна.

Нийгмийн даатгалын газрын нийт албан хаагчдад 2025 оны 05-р дугаар сард "Авлига ашиг сонирхолын зөрчил, урьдчилан сэргийлэх арга зам" сэдвийн хүрээнд Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Отгончимэг "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Р.Машбат,

нар сургалт зохион байгууллаа. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтээс зохион байгуулсан сургалтад байгууллагын эрх бүхий 18 албан тушаалтан хамрагдсан.

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн тамгын газрын шүүгчийн туслах П.Ганбүргэд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг газрын нийт 23 албан хаагчдад орсон.


Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Р.Төрбулагийн “Авлигын гэмт хэрэг ба авлигын хор хөнөөл” сэдэвт сургалтад магадлагч эмч нар танхимаар, ЭММЗөвлөлийн гишүүд болон эмч нарт авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭММТЗ-өөс 2 удаа зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан. Аймгийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчид болон газрын дэргэдэх ЭММЗөвлөл болон МХШЗөвлөлийн бүрэлдэхүүнээс баталгаа авч гарын үсэг зуруулан ажилласан байна.

Мөн тус газрын нийт 48 албан хаагчдад авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дотоодын сургалтыг 1 удаа зохион байгуулж ажилласан. Тус газрын 18 албан хаагч 2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн. 2025 онд газрын албан хаагчдаас авлига, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон албан хаагч байхгүй болно.

Тав. Архивын ажлын талаар:

Тус хэлтсийн архивт 1991-2024 оны нийт 6553 хадгаламжийн нэгж, үүнээс 70 жил хадгалах 3043 хадгаламжийн нэгж /төсөвт болон аж ахуйн нэгж, хоршоо, компаний НДШ төлөлтийн тайлан болон дотоодын баримт бичиг/, байнга хадгалах 89 хадгаламжийн нэгж, түр хадгалах 3502 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Үүнээс байцаагч ажилтнуудаас хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны 268 баримтыг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн архивлалаа. Үүнд:

- Байнга хадгалах- 8 хадгаламжийн нэгж
- 70 жил хадгалах- 157 хадгаламжийн нэгж
- Түр хадгалах- 103 хадгаламжийн нэгж



НДЕГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн №62 “Заавар батлах тухай” тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын архивын ажлын

заавар"-ыг мөрдөн зориулалтын дагуу нягтуулсан 10 сейф болон модон тавиурт архивын нэгжийг төрөлжүүлж хадгалсан.

2024 онд зогсоогдсон тэтгэврийн хувийн хэрэг

2024 онд эрхийн харилцаа дуусгавар болж зогсоогдон тус газрын дотоод хяналтаар хянацсан өндөр насны 493 тэтгэврийн хувийн хэрэг, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэврийн 439 хувийн хэрэг, тэжээгчээ алдсаны 111 хувийн хэрэг, нийт 1021 хувийн хэргийг архивт хүлээн авлаа.

№	Сум	Нийт тоо	Үүнээс		
			ӨНТ	ХЧАТ	ТАТ
1	Алагэрдэнэ	27	15	7	5
2	Арбулаг	28	14	10	4
3	Баянзүрх	39	21	12	6
4	Бүрэнтогтох	25	16	6	3
5	Галт	48	24	18	6
6	Жаргалант	47	22	19	6
7	Их уул	40	23	14	3
8	Рашаант	24	13	10	1
9	Рэнчинлхүмбэ	25	16	7	2
10	Тариалан	35	15	16	4
11	Тосонцэнгэл	41	22	14	5
12	Төмөрбулаг	34	18	14	2
13	Түнэл	30	15	13	3
14	Улаануул	25	13	8	4
15	Цагаануул	34	20	10	4
16	Цагааннуур	16	4	11	1
17	Цагаан үүр	24	13	8	3
18	Цэцэрлэг	38	23	11	4
19	Чандманьөндөр	22	9	10	3
20	Шинэидэр	20	10	9	1
21	Ханх	16	9	5	2
22	Хатгал	33	19	10	4
23	Эрдэнэбулган	22	15	5	2
24	Мөрөн	328	151	138	39
	Дүн	1021	485	419	117

Зургаа. Архивын лавлагаа олголт:

НДЕГазрын даргын 2019 оны 226 дугаар албан бичгээр хүргүүлсэн "Нийгмийн даатгалын байгууллагаас лавлагаа олгоход баримтлах зөвлөмж"-ийн дагуу хэлтэс хооронд солилцох ажлыг зохион байгуулж нийт 6 дүүрэг, 7 аймгийн цахим 45 хүсэлтийг хүлээн авч, 45 лавлагаа гаргаж, тус газраас 9 дүүрэг, 5 аймагт лавлагаа авах 35 хүсэлтийг илгээж холбогдох лавлагааг хүлээн авч ажилласан.

Нийгмийн даатгалын дэвтэр засвартай, хаяж үрэгдүүлсэн зэрэг шалтгаанаар тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохтой холбоотой цаасан суурьтай баримтаас 391 архивын лавлагаа, QR кодтой 392 лавлагаа, нийт 783 иргэнд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа олгож үйлчиллээ.

Байцаагч ажилтнуудаас хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны 268 баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээн авсан. Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн 2019 оны 1/226 тоот албан бичгийн дагуу архивын лавлагааг ирүүлсэн хүсэлтийн дагуу тус газраас гарах боломжтой лавлагааг 1 өдөрт, өөр аймаг, дүүргийн хэлтсээс авах шаадлагатай хүсэлтийг тухайн хэлтэст шилжүүлж, архивын лавлагаа гарах үйл ажиллагааг хурдан шуурхай гаргаж ажиллаж байна.

Долоо. Бичиг хэрэг, хүний нөөц:

НДЕГазар, орон нутгийн төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн албан бичиг, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг бичгээр болон утас, цахим сүлжээгээр хүлээн авч анхан шатны бүртгэлд бүртгэн удирдлагад танилцуулан шийдвэрлэх албан тушаалтанд ирсэн өдөрт нь шилжүүлэн ажиллаж байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7.1.4, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтуудыг мөрдөж, иргэдийн өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд иргэд, байгууллагаас сайн дурын даатгалын залруулга хийх хүсэлт 21, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх хүсэлт 38, тэтгэвэр дахин хянуулах хүсэлт 23, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд 109, бусад 34, нийт 225 өргөдөл гомдол хүлээн авч хуулийн хугацаанд 211 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 14 өргөдөл байна. Шийдвэрлэлт 100.0 хувьтай.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу иргэдээс тэтгэвэр тогтоолгох хүсэлт 705, тэтгэвэр өөрчлөх хүсэлт 56, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэмж тогтоолгох хүсэлт 2013, нийт 2774 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Үүнээс 18 тэтгэвэр, тэтгэмжийн өргөдөл хуулийн үндэслэл хангахгүй шалтгааны улмаас буцаагдсан. Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах төвд иргэд даатгууллагаас 16, НДЕГ-ын "Иргэд олон нийттэй харилцах 311131 утсанд 2, нийт 18 өргөдөл гомдол гаргасан. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж ажилласан. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100,0 хувьтай байна. Хуулийн хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 14 өргөдөл, гомдол нь нийт өргөдөл гомдлын 0.4 хувийг эзэлж байна.

НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дугаар тушаалын дагуу бүтэц орон тоондоо багтаан 3 хэлтсийн зохион байгуулалтаар 47 байцаагч, 6 үйлчилгээний ажилтан, нийт 53 орон тоотой ажиллахаас тайлант хугацаанд 50 албан хаагч ажиллаж байна. 2025 оны 1 дүгээр улиралд Алаг-Эрдэнэ, Тариалан сумд болон хүний нөөц, хуулийн мэргэжилтний сул орон тооны зарыг Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн боловч тус шалгалтаар орон тоо нөхөгдөөгүй бөгөөд 2 дугаар улирлын захиалгад дахин оруулахаар Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд мэдээлэл оруулан ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар хүний нөөцтэй холбоотой 24 тушаал шийдвэр гарсан байна.

Газрын албан хаагчдаас нийгмийн даатгалын улсын байцаагчийн тэргүүлэх зэрэгт 1 албан хаагч, итгэмжит зөвлөх зэрэгт 9 албан хаагч, нийт 10 албан хаагчийн судалгааг холбогдох материалын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа удирдлагын газарт хугацаанд нь хүргүүлсэн байна.

Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журмын дагуу 48 албан хаагчид, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 31 албан хаагчид, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 43 албан хаагчид, өдрийн хоолны нөхөх төлбөрийг 45 албан хаагчид Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэрэг олгох журмын дагуу 17 байцаагчид олгосон бөгөөд нийт 262679,4 мянган төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу олгосон байна. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад газрын дарга, дэс түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 байцаагч, нийт 3 албан тушаалтан суралцаж төгссөн.

Найм. Мэдээлэл технологийн талаар:

2025 оны эхний хагас жилийн байдлаар 1312 ажил олгогчийн 17139 албан журмын даатгуулагчийн тайланг НД-7,НД-8 маягтаар цахимаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг авч баталгаажуулан, сайн дурын даатгуулагч 11096 үүнээс малчин 6585, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3123, 0-3 насны хүүхдээ асарч буй эх 1170, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэг 218 даатгуулагч даатгуулж гэрээ байгуулан мэдээлэлийн санг бүрдүүлж ажиллалаа.

Шинээр 42 ажил олгогчийн 147 албан журмын даатгуулагч, сайн дурын даатгуулагч малчин 876, хувиараа хөдөлмөр эрхлэгч 239, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэг 54, 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа 94 эхийг тус тус нийгмийн даатгалд хамруулж мэдээлэлийн санд бүртгэсэн. Мөн 3 даатгуулагчийн регистрийн дугаар буруугаас алдаатай орсон цалинг зөв болгосон. Ажил олгогч, сайн дурын даатгал давхардсан тооцоог засаж 18 хүний шимтгэл төлөлтийг буцаасан. Сайн дурын даатгуулагч 32 хүний ногдуулалт давхардсан байсныг запруулсан.

2024 онд Нийгмийн даатгалын үйлчилгээнд шинэ программ нэвтрүүлж системийн шинэчлэл хийгдсэн. Үүнтэй холбогдуулан мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтнүүдэд MTT-өөс эрхийн тохиргоо хийх admin эрхийг олгосны дагуу газрын болон сумын 41 байцаагчид Sicos программд нэвтрэх эрхийн тохиргоог албан үүргийнх нь хүрээнд тохируулж, хүн тус бүрийн программд нэвтрэх нэр, нууц үгийг албаны и-мэйлээр нь илгээж баталгаажуулсан ба хүн бүрийн нууц үгийг улиралд нэг удаа дахин шинэчилж байна. Байцаагч нар программ хангамжийг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан газрын 21 албан хаагчдыг арга зүйгээр хангаж ажиллаж байна.

Ес. Сургалт мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр:

1.Ажил олгогч, иргэд даатгуулагчдыг мэдээллээр хангах чиглэлээр

Нийгмийн даатгалын ерөнхий газраас "2025 оныг "Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил" болгон зарласантай холбогдуулан батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу ажил олгогч, иргэд, даатгуулагчдад "Нийгмийн даатгалын багц хууль" болон холбогдох хууль тогтоомж, журам зааврын талаар сургалт зохион байгуулж, иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор шууд "LIVE" хийж, нээлттэй хаалганы өдөрлөг болон явуулын үйлчилгээг зохион байгуулж ажиллаа.

Үүнд: -Ажил олгогч, даатгуулагч, албан бус хөдөлмөр эрхлэгч, оюутан сурагчид, малчид, тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсч буй иргэд сургалт мэдээлэлд хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн 329 удаагийн сургалт зохион байгуулж, 12389 иргэд, даатгуулагчид хамрагдсан тоон үзүүлэлттэй байна.

2025.01.17-нд Хөвсгөл аймгийн "Хөгжимт драммын театр"-ын 26 ажилтанд "Нийгмийн даатгалын багц хууль", мөн хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн талаар сургалт мэдээлэл орлоо.

Доор дурдсан ажил мэргжлээр 20-иос доoshгүй жил, эскул нийтдээ 25-аас доoshгүй жил үүнээс 15-ас доoshгүй жил сонгодог, мэргжлийн урлагын байгууллагын тухайн ажил мэргжлээр ажилласан дааттуулагч өөрөө хүснэгтэй харгалзахгүйгээр андер насын тэтгэвэр тогтолцож болно. Үүнд:

Гоцлол дуучин
Бүхижчин
Агаарын болон хэрэглэлийн гимнастик
Акробат
Тэнцвэр, уран нугаралт
Хунд жингийн үзүүлбэрийн жүжигчин
Зэрлэг араатам, амьттан сургаж тоглуулагч
Хөөмийчин
Найрал хөгжмийн үзээвэр хөгжим

2025.01.18-нд Хөвсгөл аймгийн нийгмийн хамгааллын салбарын удирдлага, албан хаагчид ажлын уялдаа холбоог сайжруулахад хэрхэн хамтарч ажиллах талаар санаалаа солилцож хийх ажлуудын чиглэл төлөвлөгөөг гаргаж санаалаа нэгтгэлээ.



2025.01.21-нд "Хөвсгөл аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар"-ын 25-н албан хаагчдад, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар сургалт хийллээ.



2025.03.25-нд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2025 оныг салбарын хэмжээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээнд НДГ-ын Захиргаа хяналтын хэлтсийн дарга П.Майнбаяр, магадлагч эмч З.Эрчмаа, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Болорцэцэг нар оролцлоо. Нийгмийн даатгалын үйлчилгээг нэг

дороос хүргэж, гарын авлага түгээж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч зөвлөн тусалж ажиллаа. Нийт 158 иргэнд үйлчилсэн.




2025.04.03-нд Хөвсгөл аймгийн шүүх шинжилгээний хэлтэс"-ийн 12 албан хаагчдад, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар сургалт хийллээ.



2025.04.07-нд "Хөвсгөл титаник" ХХК-ны 48 ажилтан, албан хаагчдад Нийгмийн даатгалын багц хууль" сэдэвт сургалт орлоо.



2025.04.08-нд Хөвсгөл аймгийн "Хилийн цэргийн 0257-р анги"-ийн 64 албан хаагчдад, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар сургалт хийлээ.




2025.04.04-нд Хаан банк"-ны Хөвсгөл аймаг дахь салбарын 25 ажилтан, албан хаагчдад Нийгмийн даатгалын багц хууль" сэдэвт сургалт орлоо.



2025.04.12-нд Атрын-IV аяны хэлэлцүүлгийн хүрээнд Нийгмийн даатгалын газраас "Сайн дурын даатгалын ач холбогдол" сэдвээр 120 иргэнд сургалт орлоо.



2025.04.15-нд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ "ABILITY EXPO-2025" Хөвсгөл аймагт зохион байгууллагдаа. Тус арга хэмжээнд 65 иргэд, даатгуулагчдад чиглэсэн Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэл зөвлөгөө өгөх, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаа.



2025.04.17-нд Ажлын байрны хүртээмжтэй орчныг бурдүүлэх, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг байдалд хийсэн хяналт шалгалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа зэрэг сэдвийн хүрээнд ажил олгогчдод зориулсан сургалт, зөвлөгөөн зохион байгуулагдсан.


Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Зөвлөх Ч.Үндрахбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны СХГ-ын Улсын байцаагч М.Ууганбаатар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, Бодлогын хэрэгжилтийн газрын дарга У.Сосорбурам нар мэдээлэл хийлээ.

Тус арга хэмжээнд Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газраас Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Болорцэцэг, Хяналт шалгалтын байцаагч Э.Энхцэцэг, Хамралт орлого шимтгэлийн өр авлага хариуцсан байцаагч Ш.Буманцэцэг нар сургалтад хамрагдлаа.



2025.04.18-нд Нийгмийн даатгалын сангаас олгох Ажилгүйдлийн тэтгэмжийн даатгалын талаар сургалт зохион байгууллаа. Сургалт мэдээллийг НДГ-ын дарга

Л.Юмжирдулам болон Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга Б.Номин нар явуулж 15 оролцогчдын асуултад хариулт өглөө.




2025.04.23-нд Иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх мэдээ мэдээллийг өдөр тутам хүргэх зорилгоор "Гурван гал" өрхийн эрүүл мэндийн төвийн 9 албан хаагчдад сургалт, мэдээлэл хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.



2025.04.24-нд "Дэлхийн аутизмыг таниулах сар"-ын аяны хүрээнд "Аутизмтай ба тулгамдаж буй асуудал" сургалт зохион байгууллагдлаа. Хэлэлцүүлгээр 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг/эх/-ийн сайн дурын даатгалын сургалтыг Сайн дурын даатгалын байцаагч Б.Мягмаржав мэдээлэл хийж оролцогчдын асуултад хариулт өглөө.



2025.04.24-нд "Хөвсгөл аймаг дахь Шүүхийн тамгын газар"-ын 32 албан хаагчдад "Нийгмийн даатгалын багц хууль" сэдэвт сургалт орлоо.




2025.04.26-нд "Энэрэл" өрхийн эрүүл мэндийн төв"-ийн 15 албан хаагчдад "Нийгмийн даатгалын багц хууль" сэдэвт сургалт орлоо.




2025.04.26-нд Хөвсгөл аймгийн цагдаагийн газар Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар 58 албан хаагчдад сургалт орж, оролцогчдын асуултад хариулт өглөө.



2025.05.05-нд "Хөвсгөл аймгийн 9 дүгээр цэцэрлэг"-ийн 26 албан хаагчдад "Нийгмийн даатгалын багц хууль" сэдэвт сургалт орлоо.



2025.05.30-нд "Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургууль"-ийн 35 албан хаагчдад "Нийгмийн даатгалын багц хууль" сэдэвт сургалт орж, оролцогчдын асуултад хариулт өглөө.



2025.06.03-нд Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газраас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дэргэдэх бүлгийн 17 гишүүдийн "Эртэч хүн" өглөөний уулзалтад хамтран оролцоо.

Тус уулзалтаар "Сайн дурын даатгалын тухай ойлголт" сэдвийн хүрээнд сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Болорцэцэг сургалт хийж, оролцогчдын асуултад хариулт өглөө.



2025.06.04-нд Аймгийн удирдах ажилтан 6 дахь удаагын хуралдаанаар НДГ-ын дарга Л.Юмжирдулам "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, журам" сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа.



НДГ-ын болон 22 сум 1 тосгоны байцаагч нар тухайн сум орон нутгийн иргэд даатгуулагч, ажил олгогчдод "Нийгмийн даатгалын багц хууль" болон нийгмийн даатгалын бусад холбогдох мэдээ мэдээллийг хүргэх, ач холбогдлыг таниулах, сурталчлах чиглэлээр 151 удаагийн сургалт хийж 11140 даатгуулагч хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 оныг "Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил" болгож зарласантай холбогдуулан ажил олгогч, иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдлэгийг хүртээмжтэй хүргэх зорилгоор Нийгмийн даатгалын газрын page хуудсаар 6 удаагийн шууд лайв хийж, дараах сэдвийн хүрээнд мэдээ мэдээлэл түгээж ажилласан байна. Үүнд: Сайн дурын даатгал, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, Архивын лавлагаа, Өндөр насны тэтгэвэр, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, Тэтгэмжийн даатгал гэсэн чиглэлүүд хамрагдсан. Шууд бичлэгийг иргэд даатгуулагчдад хүргэж 230 лайк, 55 коммент, 20422 хандалтийг

тус тус авсан байна. Мөн 10 удаагийн видео бичлэг байршуулж, 301 лайк, 27 коммент, 26510 хандалтыг авсан байна.



Нийгмийн даатгалын газрын page хуудсаар Иргэд даатгуулагчдад чиглэсэн сонирхол татахуйц 31 постийг оруулж 416 лайк, 453 удаа хуваалцаж, 27876 хандалтыг авсан байна.



Хөвсгөл аймгийн Иргэд, даатгуулагчдад мэдээ мэдээллийн интертаймент Khoimog.mn сайтаар Хөвсгөл аймгийн НДГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулга, Өндөр насын тэтгэврийн тусгай зохицуулалтын тухай, Тэтгэврийн нэмэгдлийн тухай, Малчин нөхцөлөөр өндөр настны тэтгэвэр хэрхэн тогтоолгох тухай, Өндөр насын тэтгэврийн тухай, Малчны өндөр насын тэтгэврийн тухай контент, рийлийг нийтлэн хүргэж 991 лайк, 61 сэтгэгдэл, 365 удаа хуваалцаж, 53700 хандалтыг авсан байна.



“Нээлттэй хаалганы өдөрлөг” болон зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд “БҮТЭЭЛЧ ХӨВСГӨЛЧҮҮД” НДЕГазраас 2025 оныг Даатгуулагчдын жил болгон зарласантай холбогдуулан “БИД ТАНД ҮЙЛЧИЛЬЕ” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 15-нд нийгмийн салбарын агентлагуудтай хамтран амжилттай зохион байгууллаа.

Тус өдөрлөгөөр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн шинэчлэл, цахим үйлчилгээний талаар мэдээлэл өгөхөөс гадна иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, гэрээ байгуулах, шимтгэл хэрхэн төлөх, ажилласан хугацааг тооцох, иргэн хүсэлтээ цахимаар хэрхэн илгээх талаар зөвлөгөө мэдээлэл өгч, нийт 154 иргэд, даатгуулагчдад гарын авлага тараан нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, нээлттэй, хүртээмжтэй хүргэн ажиллаа.




"Хүрч үйлчилье" явуулын үйлчилгээ зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын "Бүтээлч Хөвсгөлчүүд" үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 оныг "Даатгуулагчийг дэмжих" жил мөн "Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба" аянтай холбогдуулан бизнес эрхлэгч, даатгуулагчдад "Хүрч үйлчилье" явуулын үйлчилгээ 2025 оны 05 сарын 01-ний өдрөөс 05 сарын 07-ны өдрийн хооронд амжилтай зохион байгууллаа.

Хөвсгөл аймгийн томоохон зах худалдааны төвүүд болох Цагаан уул зах, Далай ээж зах, Номин ХҮТ, Эрхэс ХҮТ, Бишрэлт ХҮТ, Титэм-1, Титэм-2, Мустанг, Баян цагаан худалдааны төв, Талст ХҮТ, Тэнхлэг их дэлгүүр, Далай ээж ХҮТ, Бараан зах, Мөрөн Дэлгүүр, Од дэлгүүр, Эрдэнэт хивс, Мичид дэлгүүр, Бишрэлт дэлгүүр, гэсэн газруудад явуулын үйлчилгээ зохион байгууллаа.


Явуулын үйлчилгээгээр 315 ширхэг сурталчилгааны материал тарааж, 458 иргэнд хүрч үйлчилж ажилласан байна.





1. Газрын байцаагч, мэргэжилтнүүдийг хөгжүүлэх чиглэлээр:

2025.01.03-нд "Төрийн жинэхэн албан хаагчийн гүйцэтгэлийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсоруулж, батлах, ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын талаар чадавхжуулах сургалтыг нийт сумдын байцаагч нарт Газрын дарга Л.Юмжирдуулам цахимаар сургалт орж арга зүйн зөвлөгөө өглөө.




2025.01.06-нд "Төрийн жинэхэн албан хаагчийн гүйцэтгэлийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсоруулж, батлах, ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын талаар чадавхжуулах Нийгмийн хамгааллын улсын байцаагч Ч.Нямгэрэл нийт албан хаагчид сургалт орлоо.




2025.01.07-нд "Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, анхаарах зарим асуудал" талаар Хөвсгөл аймаг дахь Тагнуулын газрын Ахлах мэргэжилтэн Нэргүй, Тагнуулын газрын мэдээллийн нууцлал хамгаалах мэргэжилтэн Түмэнжаргал нийт албан хаагчид сургалт орлоо.

2025.01.14-нд "Хувь хүний хөгжил" "Гэр бүл хайрын ертөнц" сэдэвт сургалт зохион байууллаа. Иргэдэд нөлөөллийн аргаар танхимаар лекц харилцан яриа хэлбэрээр албан байгууллагууд болон иргэд оролцов. Сургалтыг "Үр жимстэй гэр бүл"ТББ-ын сургагч багш лектор Г.Шижирбаатар орлоо

2025.01.15-нд"Үндэсний бичиг"-ийн сургалт зохион байууллаа.Нийт албан хаагчдад үндэсний бичгийн сургалтыг ЭДЦС-ын МХБУЗ багш Н.Батцэцэг орлоо.





2025.01.21-нд “Зөрчлийн бүртгэл мэдээллийн сангийн нэгдсэн систем” Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтануудад Зөрчлийн хэргийн прокуроор н.Батсүх сургалт орлоо.

2025.01.22-нд “Илүү төлсөн шимтгэл буцаалтыг олгох тухай” сургалтыг НДЕГ-ын Мэдээллийн технологийн төвөөс сургалтыг зохион байгууллаа.

2025.01.22-нд “Тэтгэврийн зөрүү хуваарь үүсгэх, Тэтгэврийн олголт хаах, Үйлдвэрлэлийн ослын сангаас хариуцах ногдуулалт үүсгэх” талаар сургалтыг НДЕГ-ын Мэдээллийн технологийн төвөөс сургалтыг зохион байгуулсан.

2025.01.30-нд “Тэтгэврийн хуваарь засах” талаар сургалтыг НДЕГ-ын Мэдээллийн технологийн төвөөс сургалт зохион байгуулсан.

2025.02.07-нд “Тэтгэмжийн тайлан хэрхэн гаргах” талаар сургалт зохион байгууллагдаа НДЕГ-ын Мэдээллийн технологийн төвөөс сургалт зохион байгууллаа.

2025.02.07-нд “Ёс зүйн дэд хорооноос ажиллах журам, Ёс зүйн зөрчлийг бүртгэх хяналтын дэд системийг ашиглах, системд бүртгэгдсэн мэдээллийг хянах” заавар зөвлөгөө өгөх сургалтыг НДЕГ-ын Ёс зүйн хорооноос сургалт орлоо.

2025.02.15-нд Нийгмийн хамгааллын салбарын зөвлөгөөн зохион байгуулагдсан. Нийгмийн хамгааллын салбарын 3-н аймгийн албан хаагчид 2 өдөр сургалтыг үр дүнтэй явуулсан.



2025.02.21-нд Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт, мэдээлэл сургалтыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын "Соёмбо" танхимд Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт, мэдээллийн талаар сургалт хийллээ.

2025.02.24-нд Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас GOV.MN-ны ашиглалт ба хэрэглээ сургалтыг төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас GOV.MN-ны ашиглалтын сургагч багш Б.Анар цахимаар орлоо.

2025.02.24-нд "Төрийн албаны шинэтгэл" сэдэв сургалтыг төрийн албаны зөвлөлөөс зохион байгууллаа.

2025.02.24-нд Тэтгэвэр тогтоолттой холбоотой сургалтыг НДЕГ-аас сургалтыг зохион байгуулсан.

2025.03.11-нд Шидэт гар' дохионы хэлний сургалтыг дохионы хэлний багш, орчуулагч, доктрант, Б.Саранчимэг багш 'Шидэт гар' дохионы хэлний сургалт орлоо.



2025.03.16 Жагсаалтаар олгосон тэтгэврийн бүртгэлийг хийх шинэ нэмэгдсэнтэй холбоотой цахим сургалт НДЕГ-аас сургалтыг зохион байгуулж явууллаа.

2025.03.21 "Финтекс ба криптовалют" сэдэвт сургалтыг ОНСБТ-ийн эдийн засагч, Г.Ананд орлоо.



2025.03.21 "Жендер ба бодлого төлөвлөлт' сургалтыг Их уул сумын Иргэдийн хурлын төлөөлөгч, хурлын дарга Б.Лхагважав, Их уул сумын Засаг даргын Б.Билэгбаяр, Аймгийн ЗДТГ, Жендерийн эрх тэгш байдал, салбар, дундын бодлого, зохицуулалт хариуцсан Г.Цэцэгдарь, нар оролцов.



2025.03.27-нд Зарлан мэдээллийн дуут дохиогоор гамшигаас сэргийлэх дасгал сургуулилтанд оролцлоо. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340

дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх" журамд заасны дагуу жил бүрийн 03 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гарагийн 16.00 цагт улс орон даяар "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дуугарч, улс орон даяар дадлага сургуулилт явагдлаа.




2025.03.29-нд "Үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах арга зүй" сургалт зохион байгууллаа. НДЕГазраас, АЕГ-тай хамтран зохион байгуулан явуулав.

2025.04.03-нд "Тогтвортой хөгжлийг дэмжсэн төрийн албан хаагчийн цогц чадамж" сургалтыг Удирдахуйн ухааны доктор (Ph.D), профессор Н.Наранчимэг, МУБИС-ийн Сэтгэл судлалын тэнхимиийн эрхлэгч, доктор(Ph.D) Г.Галсанжамц, Байгаль орчны мэдээлэл сургалтын төвийн гүйцэтгэх захирал, тогтвортой хөгжлийн боловсролын сургагч багш Э.Шинэцэцэг нар орлоо.



2025.04.04-нд "Ажлын бүтээмжид стресс нөлөөлдөг" сэдэвт сургалт зохион байууллаа. "Нийтийн далд ухамсыг сээрэх баярлалаа төв"-ийн зөвлөх багш П.Тунаараа орлоо.




2025.04.07-нд "Харилцаа хандлага" сэдэвт сургалт зохион байууллаа. Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмч, Н.Үүрцайх сургалт орж, мэдээлэл өгч ажиллалаа.



2025.04.27-нд Sicos программын сургагч багш бэлтгэх чадавхжуулах сургалтыг НДЕГ-аас сургалтыг зохион байгуулж явуулсан.



2025.05.07-нд "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр НДГ-ын нийт албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Тус сургалтыг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Р.Машбат, мэргэжилтэн Б.Отгончимэг нар явууллаа.




2025.05.13-нд "Эрүүл зөв хооллолт" сургалт зохион байгууллаа. Сургалтыг ЭМГ-ын хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн П.Лхагвасүрэн орлоо




2025.05.16-нд "Нийгмийн даатгалын байгууллагын авлагын менежмент, авлагыг барагдуулах арга зам" сургалтыг цахимаар зохион байгууллаа. НДЕГ-аас сургалтыг зохион байгуулж явуулсан.


2025.05.11 Сумдын байцаагч нарыг чадавхжуулах, sicos системийн сургалтыг Нийгмийн хамгааллын улсын хяналтын байцаагч Ч.Нямгэрэл, Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга Б.Номин нар 23 сумын 24 байцаагч наарт цахим зохион байгуулан явуулаа.




2025.05.26-нд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаал "Аргачлал, загвар батлах тухай" сэдэвт сургалт орлоо. НДГ-ын дарга Л.Юмжирдулам сургалт явуулав.



2025.03.21-2025.06.06 НДЕГ-ын мэдээллийн цагийн хуваарийн дагуу Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан батлагдсан тогтоол, тушаал, дүрэм, журмыг танилцуулах сургалтыг НДЕГ-ын албан хаагчид 10 удаа зохион байгуулан явуулж байна.



2025.01.01-2025.06.04 Сумдын байцаагч нарыг чадавхжуулах, эрсдэлээс сэргийлэх сургалтуудыг НДГ-ын дарга болон хэлтсийн дарга нар зохион байгуулан явуулж байна.



2. Сумдын байцаагч нар сургалт, мэдээлэл хийсэн талаар:

Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны байцаагч нар тухайн сум орон нутгийн иргэд даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд даатгуулагчиддаа сурталчлан таниулах, ажлын хүрээнд Аймгийн засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан “БҮТЭЭЛЧ ХӨВСГӨЛЧҮҮД” малчдын зөвлөгөөнд оролцож, сургалтууд хийсэн байна.

Сургалт зөвлөгөөнд оролцсон 250 гаруй малчдад Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд малчны тэтгэврийн мэдээлэл, сайн дурын даатгалын шимтгэл төлөлт, нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдлын талаар Арбулаг сумын Нийгмийн даатгалын улсын байцаагч А. Сумъяа сургалт мэдээлэл хийж, иргэд даатгуулагчдын санал хүсэлтэд хариу өгч, санал солилцож, сумын хэмжээнд тухай бүр мэдээ мэдээллийг хүргэж ажилласан байна.



Тус зөвлөгөөнд Рашаант сумын Нийгмийн даатгалын байцаагч Н.Өлзийжаргал Нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдол, малчны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар зөвлөгөөнд оролцсон 205 малчдад сургалт хийн санал солилцлоо.



Зөвлөгөөнд оролцсон 200 гаруй малчдад Нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдол, малчны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар Галт сумын Нийгмийн даатгалын байцаагч Е.Дэлгэрсайхан сургалт хийж, санал солилцлоо.




Зөвлөгөөнд оролцсон 216 малчинд Нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдол, малчны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар сургалт хийж,

Жаргалант сумын Нийгмийн даатгалын байцаагч Г.Пүрэвхишиг , гарын авлага материал тараан Нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлан ажиллаа.



Зөвлөгөөнд оролцсон 200 гаруй малчдад Нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдол, малчны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар Тариалан сумын Нийгмийн даатгалын байцаагч Э.Энхзаяа сургалт хийж, санал солилцлоо.




Зөвлөгөөнд оролцсон 232 гаруй малчид Нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдол, малчны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар Баянзүрх сумын Нийгмийн даатгалын байцаагч Д.Отгонбаяр сургалтыг хийж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгэн ажиллаа.



Тус зөвлөгөөнд Шинэ-Идэр сумын 200 гаруй малчид оролцлоо. Нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдол, малчны тэтгэвэр, сайн дурын

даатгалын талаар сургалтыг Шинэ-Идэр сумын Нийгмийн даатгалын байцаагч Ц.Өлзийбадрах сургалтыг хийж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгөн ажиллаа.



Тус зөвлөгөөнд Алаг-Эрдэнэ сумын 200 гаруй малчид оролцлоо. Малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар сургалтыг Хатгал сумын Нийгмийн даатгалын байцаагч Д.Нандинцэцэг сургалтыг хийж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгөн ажиллаа.



Тус зөвлөгөөнд Төмөрбулаг сумын 200 гаруй малчид оролцлоо. Нийгмийн даатгалд даатгуулсаны үр дүн, ач холбогдол болон малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар мэдээллийг Төмөрбулаг сумын Нийгмийн даатгалын байцаагч Д.Чимэдбальдар сургалтыг хийж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгөн ажиллаа.



Тус зөвлөгөөнд Тариалан сумын 225 малчин оролцлоо. Энэхүү арга хэмжээний хүрээнд: Нийгмийн даатгалд даатгуулсаны үр дүн, ач холбогдол болон малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар мэдээллийг Тариалан сумын Нийгмийн даатгалын байцаагч Э.Энхзаяа сургалтыг хийлээ.



Тус зөвлөгөөнд Тосонцэнгэл сумын 200 гаруй малчид оролцлоо. Малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар сургалтыг Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын байцаагч С.Эрдэнэтуяа сургалтыг хийж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгөн ажиллаа.



Тус зөвлөгөөнд Хатгал тосгоны 151 малчин оролцлоо. Малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар сургалтыг Хатгал тосгоны Нийгмийн даатгалын байцаагч Д.Нандинцэцэг сургалтыг орж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгөн ажиллаа.



Тус зөвлөгөөнд Цагаан-Үүр сумын 200 гаруй малчид оролцлоо. Нийгмийн даатгалд даатгуулсаны үр дүн, ач холбогдол болон малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар сургалтыг Цагаан-Үүр сумын Нийгмийн даатгалын байцаагч Д.Энхтувшин сургалтыг хийж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгөн ажиллаа.



Тус зөвлөгөөнд Улаан-Уул сумын 200 гаруй малчид оролцлоо. Нийгмийн даатгалд даатгуулсаны үр дүн, ач холбогдол болон малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар сургалтыг Улаан-уул сумын Нийгмийн даатгалын байцаагч Б. Цэвээнравдан сургалтыг хийж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгөн ажиллаа.



Тус зөвлөгөөнд Цэцэрлэг сумын 228 малчин оролцлоо. Энэхүү арга хэмжээний хүрээнд: Нийгмийн даатгалд даатгуулсаны үр дүн, ач холбогдол болон малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар мэдээллийг Цэцэрлэг сумын Нийгмийн даатгалын байцаагч Д.Өлзий-Очир сургалтыг хийж, иргэдийн саналыг хүлээн авч хариулт өгөн ажиллаа.



Энэхүү зөвлөгөөнд хоршооны төлөөлөл, Малчдын төлөөлөл, Залуу малчдын төлөөлөл, Мал аж ахуй эрхлэгч фермер, Мал аж ахуйн чиглэлээр өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл, Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн төлөөлөл 208, удирдлагуудын төлөөлөл, төрийн албан хаагч 36 нийт 244 иргэн оролцлоо.

Тус арга хэмжээний хүрээнд: Нийгмийн даатгалд даатгуулсаны үр дүн, ач холбогдол болон малчны өндөр насны тэтгэвэр, сайн дурын даатгалын талаар сургалтыг Цагаан-Уул сумын Нийгмийн даатгалын байцаагч Ц.Оюунлхагва Д.Эрдэнэзүл нар сургалтыг орж иргэдээс ирсэн саналыг хүлээн авч 46 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгөн ажилласан байна.



№	Сумдын нэрс	Албан байгууллага иргэд, даатгүү				Албан байгууллага цээд даатгуулавчийн чиаласын сургалт, Үүнээс:										
		Сургалтад хамрагдсан нийтийн тоо	Сургалтад хамрагдсан даатгүүн ажийн нийтийн тоо	Хамрагдсан даатгүүн ажийн нийтийн тоо	Сургалт түн тоо	Аж ахуй нээгийн тоо	Хамрагдсан даатгүүн улаачийн тоо	Сургалт түн тоо	Базарын тоо	Хамрагдсан даатгүүн улаачийн тоо	Сургалт түн тоо	Сургуулийн тоо	Хамрагдсан оюутан, сургалт чадвын тоо	Сургалт түн тоо	Баягийн тоо	Хамрагдсан малчидын тоо
1	АРБУЛАГ	17	18	883	6	8	181	4	4	52	0	0	0	7	6	650
2	БҮРЭНТОГОТХОК	4	10	366	1	3	5	1	1	80	0	0	0	2	6	281
3	БАЯНЗУРХ	9	9	597	3	3	88	2	2	58	0	0	0	4	4	451
4	ГААНТ	5	16	330	3	10	10	1	1	30	0	0	0	2	5	290
5	ЖАРГАЛАНТ	3	3	181	2	2	71	0	0	0	0	0	0	1	1	110
6	ИХ УУЛ	6	6	263	0	0	0	1	1	58	0	0	0	5	5	205
7	ТҮНЭЗЛ	5	10	411	0	0	0	3	3	185	1	1	25	1	6	201
8	ТОСОНЦЭНГЭЛ	5	10	187	2	7	98	0	0	0	0	0	0	3	3	89
9	ТАРИАЛАН	6	63	882	1	56	56	1	1	20	1	1	16	3	5	790
10	ТӨМӨРБУЛАГ	8	25	686	1	17	17	2	3	58	0	0	0	5	5	811
11	РАШАНТ	13	12	1502	3	3	26	1	3	36	1	1	67	8	5	1373
12	УЛААН УУЛ	7	14	832	1	8	264	3	3	68	0	0	0	3	3	500
13	ЦАГААН УУЛ	16	16	1257	5	5	115	3	3	78	1	1	51	7	7	1013
14	ЦАГААН ҮҮР	4	14	643	1	8	61	1	3	191	0	0	0	2	3	391
15	ЦАГААННҮҮР	14	35	520	3	31	74	5	2	40	0	0	0	9	2	406
16	ЦАЦЭРЛЭГ	2	2	253	0	0	0	0	0	0	0	0	0	2	2	253
17	ШИНЭ ИДЭР	11	13	698	4	6	166	3	3	67	0	0	0	4	4	465
18	ЭРДЭНЭБҮЛГАН	7	23	352	1	15	35	3	3	30	0	0	0	3	5	287
19	ХАТГАЛ	8	8	597	2	2	39	3	3	58	0	0	0	3	3	500
20	ХАНХ	2	5	156	0	0	0	0	0	0	1	1	30	1	4	126
	Нийт дун	153	312	11596	39	184	1306	32	39	1109	5	5	189	75	84	8992

САНХҮҮ БҮРТГЭЛ, ОРЛОГО ХАМРАЛТЫН ХЭЛТЭС

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын санхүү бүртгэл, хамралт орлогын хэлтэс нь Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга 1, хамралт орлого шимтгэлийн өр хариуцсан байцаагч 2, сайн дурын даатгалын байцаагч 1, сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн 2, үйл ажиллагааны нягтлан бодогч 1, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлагдсан орон тоогоор ажиллаж байна.

1. Нийгмийн даатгалын сангийн орлогын талаар:

Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, өр авлагыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2025 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын санд 1312 аж ахуйн нэгж байгууллагаас 29938631.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, 11096 сайн дурын даатгуулагчаас 2449573.8 мянган төгрөгийн шимтгэлийн орлого, эхийн хүүхэд асрах хугацааны төсөв, тэтгэмжийн сангаас төлсөн шимтгэлийн орлого 28354.1 мянган төгрөг, малчин, туслах малчны төсвөөс төлсөн шимтгэл 1855480.4 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхийн төсвөөс төлсөн шимтгэлийн орлого 213236.3 мянган төгрөг, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 13464.0 мянган төгрөг, цаатан иргэдийн шимтгэлийн орлого 70063.0 мянган төгрөг, нийт шимтгэлийн орлого 34658803.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 100.2 хувиар биелүүллээ.

Орлогын төлөвлөгөөг харуулвал:

/ мян.төг/

Сар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	4898146.2	4778932.9	97.6
2	9832052.6	10331319.3	105.1
3	15668627.1	15967026.7	101.9
4	21292479.4	21512531.8	101.0
5	27929688.6	27571124.2	98.2
6	34559003.4	34658803.4	100.2

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй 2090 аж ахуйн нэгж байгууллагаас 441 аж ахуйн нэгж, байгууллага Х тайлан гаргадаг бол цалин хөлсөөр тайлагнасан 1649 аж ахуйн нэгж байна. Үүнээс нийгмийн даатгалд 1312 байгууллага буюу 79.5 хувь нь НД7, НД8 маягтаар тайлагнадаг.

2025 онд шинээр 42 ажил олгогч, 147 албан журмын даатгуулагчийг нийгмийн даатгалд шимтгэл төлөгчөөр хамруулсан.

2. Сайн дурын даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2025 оны хагас жилийн байдлаар сайн дурын даатгалд 11096 даатгуулагч хамрагдсанаас малчин 6585, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3123, 0-3 насны хүүхдээ асарч буй эх 1170, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэг 218 даатгуулагч даатгуулсан. Үүнээс: Шинээр малчин 876, хувиараа хөдөлмөр эрхлэгч 239, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэг 54, 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа 94 эхийг тус тус нийгмийн даатгалд хамруулсан.

Сайн дурын даатгалд шинээр хамрагдах иргэдийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны А/200 тоот шинэчлэгдсэн журмын дагуу эхний сарын шимтгэл төлснөөр холбогдох баримтыг бүрдүүлж гэрээг цаасаар болон цахимаар авч баталгаажуулсан.


ХХҮГазарт бүртгэлтэй цалинтай эхчүүдийн судалгааг сум тус бүрээр гаргуулан авч үзэхэд нийт 6210 цалинтай эхчүүд хамрагдснаас ажил олгогч байгууллагаас шимтгэл нь төлөгддөг 547, тухайн орон нутагтаа байхгүй 211, сайн дурын даатгал төлдөг 109, нэн ядуу амжиргааны түвшин доогуур орлоготой 67 эх байна. Үлдсэн 5276 эхчүүдтэй утсаар ярьж, биечлэн уулзаж 3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг даатгуулсан эсэхээс үл хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс төлөх тухай зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.

Аймгийн хэмжээнд 3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50

хувийг даатгуулсан эсэхээс хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсвэл улсын төсвөөс төлсөн нийт 1170 даатгуулагч хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт, цахим үйлчилгээний талаар сайн дурын даатгуулагч нарт сургалт сурталчилгаа, мэдээлэл хийж ажилласан.

2025.04.12-нд Атрын-IV аяны хэлэлцүүлгийн хүрээнд Нийгмийн даатгалын газраас "Сайн дурын даатгалын ач холбогдол" сэдвээр 120 иргэнд сургалт орлоо.



2025.04.15-нд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ "ABILITY EXPO-2025" Хөвсгөл аймагт зохион байгууллагдлаа. Тус арга хэмжээнд 65 иргэд, даатгуулагчдад чиглэсэн Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэл зөвлөгөө өгөх, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаа



2025.04.24-нд “Дэлхийн аутизмыг таниулах сар”-ын аяны хүрээнд “Аутизмтай ба тулгамдаж буй асуудал” сургалт зохион байгууллагдлаа. Хэлэлцүүлгээр 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг/эх/-ийн сайн дурын даатгалын сургалтыг Сайн дурын даатгалын байцаагч Б.Мягмаржав мэдээлэл хийж оролцогчдын асуултад хариулт өглөө.



НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:


Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг арилжааны банк болон төрийн сангаар өдөр бүр төвлөрүүлж нэгж дээрх орлого хуваарилалтыг тогтмол хийж 34497157.3 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн.

3. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бүүрүулах талаар:

Хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайдын 2023 оны А/199 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлاغнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ыг танилцуулах, нийгмийн даатгалын мэдээллийн шинэ систем нэвтрүүлэх шилжилтийн үетэй холбоотойгоор шимтгэлийн орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлж, НД7, НД8 тайланг сар бүр илгээх, илгээсэн тайланг хянаж баталгаажуулсаны дараа хэвлэж, цаасаар ирүүлэх талаар төсөвт болон аж ахуйн нэгжийн нягтлан бодогч нарт сургалт хийж нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан авалтын хувийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагын дарга, нягтлан бодогч нарт "Байгууллагын шимтгэлийн тайлан гаргах, шимтгэлий өр авлага үүсгэхгүй байх, барагдуулах, тэтгэмж бodoх, олгох" талаар нэгдсэн сургалтыг хийсэн.


2025.04.04-нд Хаан банк"-ны Хөвсгөл аймаг дахь салбарын 25 ажилтан, албан хаагчдад Нийгмийн даатгалын багц хууль" сэдэвт сургалт орлоо.



2025.05.05-нд "Хөвсгөл аймгийн 9 дүгээр цэцэрлэг"-ийн 26 албан хаагчдад "Нийгмийн даатгалын багц хууль" сэдэвт сургалт орлоо.



2025.06.04-нд Аймгийн удирдах ажилтан 6 дахь удаагын хуралдаанаар НДГ-ын дарга Л. Юмжирдуулам "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, журам" сэдвийн хурээнд сургалт зохион байгууллаа.



Нийгмийн даатгалын өрөнхий газраас "2025 оныг "Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил"-ийн хүрээнд ажил олгогч, иргэд даатгуулагчдыг Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдлэгийг хүртээмжтэй хүргэх үүднээс шууд "LIVE" хийсэн



Өмнөх оны эхний үлдэгдэл 2323966.6 мянган төгрөг байгаагаас нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын насжилт өндөртэй шимтгэлийн өртэй газруудын удирдлага, нягтлан бодогч нартай удаа дараа уулзаж өр барагдуулах график байгуулж ажилласны үр дүнд өмнөх оны шимтгэлийн авлагаас төсөвт байгууллагаас 187518.5 мянган төгрөгийг бүрэн барагдуулж, аж ахуйн нэгж байгууллагаас 582555.8 мянган төгрөг, нийт 770074.3 мянган төгрөгийг төвлөрүүлж 79.0% бууруулж ажилласан. Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн урсгал өрийг барагдуулахад онцгой анхаарч данс хаах мэдэгдлээр 5 ажил олгогчоос 35802.3 мянган төгрөг, албан шаардлагыг 6 ажил олгогчид өгч 22311.0 мянган төгрөг, өр барагдуулах графикийг 33 ажил олгогчтой хийж 503802.4 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж, нийт нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2186207.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өмнөх оны төсөвт байгууллагын шимтгэлийн авлага 187518.5 мянган төгрөг байсныг бүрэн барагдуулж, эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагагүй ажиллаж байна

Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын бусад өр, авлагыг шалгах, шинэчлэн баталгаажуулах, барагдуулах ажлын хүрээнд:

- а/ Нийгмийн даатгалын сангийн бусад өглөг, авлагыг сум бүрээр, даатгуулагч бүрээр тооцооны үлдэгдлийг шинэчлэн баталгаажуулж. Бусад өглөгийн өмнөх оны үлдэгдэл 68823,4 мянган төгрөгийг бүрэн барагдуулж ажилласан. Энэ оны үлдэгдэл даатгуулагч бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.
- б/ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангаар гарсан үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан болно.

4. Нийгмийн даатгалын сангийн зардлын талаар:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дугаар сарын 6-ний өдрийн А/01 тоот тушаалаар нийгмийн даатгалын сангийн зардлын төсөв 110620963.0 мянган төгрөгөөр батлагдсан. Үүнээс:

- ✓ Тэтгэврийн даатгалын сангаас 22623 тэтгэвэр авагчдад 101337519.4 мянган төгрөгийн тэтгэвэр
- ✓ Тэтгэмжийн даатгалын сангаас 2023 даатгуулагчдад 4143915.5 мянган төгрөгийн тэтгэмж
- ✓ ҮОМШӨ сангаас 61 тэтгэвэр авагчдад 365102.5 мянган төгрөгийн тэтгэвэр, 18 даатгуулагчид 9108.0 мянган төгрөгийн тэтгэмж, төлбөр
- ✓ Ажилгүйдлийн даатгалын сангаас 354 даатгуулагчид 1230539,5 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын хуулийн дагуу цаг хугацаанд нь бүрэн олгосон.

2025 оны эхний хагас жилийн байдлаар зарцуулалтыг төрлөөр нь задалбал:

- ✓ Өндөр насны тэтгэвэрт 19404 тэтгэвэр авагчдад 83777812.6 мянган төгрөг
- ✓ Тахир дутуугийн тэтгэвэрт 1822 тэтгэвэр авагчдад 9957976.9 мянган төгрөг
- ✓ Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 938 тэтгэвэр авагчдад 3652795,7 мянган төгрөг
- ✓ Цэргийн алба хаасны тэтгэвэрт 459 тэтгэвэр авагчдад 3948934,2 мянган төгрөгийг улсын төсвөөс
- ✓ ҮО-ын сангаас 61 тэтгэвэр авагчдад 365102.5 мянган төгрөг
- ✓ ХЧТА-ы тэтгэмжийг 691 даатгуулагчдад 156620.4 мянган төгрөг
- ✓ Жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг 990 даатгуулагчид 3435295.1 мянган төгрөг
- ✓ Оршуулгын тэтгэмжинд 342 даатгуулагчид 684000.0 мянган төгрөг
- ✓ ҮОМШӨ-ний даатгалын тэтгэмж, төлбөрт 18 даатгуулагчид 9108.0 мянган төгрөг
- ✓ Ажилгүйдлийн тэтгэмжийг 354 даатгуулагчид 1230539.5 мянган төгрөгийг цаг хугацаанд төсвийн хуваарийн дагуу зарцууллаа.

5. Байгууллагын үйл ажиллагааны зардлын талаар:

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны үйл ажиллагааны зардалд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 тоот тушаалын 2-р хавсралтаар 1253082.7 мянган төгрөгийн төсвийг баталсан. Үүнээс:

- Цалингийн зардалд: 891706,5 мянган төгрөг
- Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 111025,4 мянган төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 23110,0 мянган төгрөг
- Томилолтын зардал 2661,6 мянган төгрөг
- Бичиг хэргийн зардал 1795,0 мянган төгрөг
- Шуудан холбооны зардалд 1028,0 мянган төгрөг
- БҮТЭЗҮйл 743,3 мянган төгрөг
- Урсгал засварт 20941,5 мянган төгрөг, шатахууны зардалд 751,1 мянган төгрөг
- Хог хаягдал зайлцуулах зардалд 60,0 мянган төгрөгийг
- Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 430,0 мянган төгрөгийг

батлагдсан төсөвт багтаан хөтөлбөр зориулалтын дагуу зарцуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна мянган төгрөгийг батлагдсан төсөвт багтаан хөтөлбөр зориулалтын дагуу зарцуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/22 тоот тушаалын дагуу З хэлтсийн зохион байгуулалттай 52 орон тоо батлагдсан. Батлагдсан зардлыг зарцуулахдаа Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, Ахмадын сангийн журам, Сангийн сайдын 2014 оны № 5, № 55, 2015 оны № 7, 2006 оны № 388 болон Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу санхүү, нягтлан бодох бүртгэлийн программ ашиглан анхан шатны баримтад үндэслэн гүйлгээ хийж, албан хаагчдын цалин хөлсийг бодож олгохдоо байгууллагын санхүүгийн программ болон Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр давхар хөтлөн тооцоолол хийж, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг тухай бүр гаргаж тооцоо хийж тайлагнасан. Мөн үнэт цаас, эд хөрөнгө хариуцсан ажилтны боловсруулсан тайлан, жолоочийн замын хуудсын тооцоог хянаж, удирдлага арга зүйгээр хангаж, цахилгаан, дулаан, усны болон бусад газруудтай гэрээ байгуулж, тооцоо нийлж баталгаажуулсан.

2025 оны хагас жилийн байдлаар 1110799.5 мянган төгрөгийн санхүүжилт 909184.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг бүртгэж ажилласан.

6. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны тайлан гаргалтын талаар:

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, Нийгмийн даатгалын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээ, Нийгмийн даатгалын сангийн өр авлагын мэдээний иж бурдлийн дагуу үнэн зөв хугацаанд нь 6 удаа гаргаж Нийгмийн даатгалын санхүү бүртгэлийн газарт өгч нэгтгүүлсэн..

Анхан шатны баримтыг үндэслэн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйлгээг давхардсан тоогоор төвлөрсөн харилцахын орлого, зарлагын бүртгэлийг 26284 шилжүүлгээр 68459243.7 мянган төгрөг, тэтгэврийн харилцахын орлого, зарлагын бүртгэлийг 580 шилжүүлгээр 169253489.8 мянган төгрөг, тэтгэмжийн сангийн харилцахын орлого, зарлагын бүртгэлийг 2007 шилжүүлгээр 10181270.6 мянган төгрөг, ҮОМШӨ-ний харилцахын орлого, зарлагын бүртгэлийг 109 шилжүүлгээр 777925.6 мянган төгрөг, ажилгүйдлийн сангийн харилцахын орлого, зарлагын бүртгэлийг 731 шилжүүлгээр 2705706.0 мянган төгрөгийн мэдээллийг харилцахын цахим мэдээллийн санд хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мэдээллийн шинэ систем нэвтрүүлж байгаа ажлын хүрээнд:

- 1.Дансны хуулга уншуулах, боловсруулах
- 2.Төвлөрсөн харилцах дансны орлогыг:
- 3.Ажил олгогчийн эхний үлдэгдлийг тулган баталгаажуулах
- 4.Энгийн СДД-ийн эхний үлдэгдлийг баталгаажуулах
- 5.Нэхэмжлэл үүссэн тэтгэмж: ХЧТА-ны тэтгэмж, ЖА-ны тэтгэмж

Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж зэрэг зарлагын гүйлгээний өглөгийг таниулж хаах ажлыг дэс дараатай хийж гүйцэтгэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журам, НДЕГ-ын даргын 2023 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах журам”-ыг тус тус баримтлан байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөөний дагуу үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жилийн тооллогыг зохион байгуулж нийт 50590,2 мянган төгрөгийн хөрөнгийг тоолж баталгаажуулснаас барилга байгууламж дансанд 348814,3 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл дансанд 10485,0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж дансанд 70689,5 мянган төгрөг, тавилга, эд хогшил дансанд 24073,9 мянган төгрөг, биет бус хөрөнгө дансанд 51839,3 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайлан баланстай тулган баталгаажуулж, бүртгэж ажилласан.

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний дагуу хэлтсийн хөрөнгөнд бүртгэлтэй газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгийн нэгдсэн судалгааны маягтууд болох ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон статистикийн мэдээ тайланг бэлтгэн НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Мөн Төрийн өмчийн тооллогын нэгдсэн системд байгууллагын санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөлийг бүртгэн баталгаажуулсан. Үндсэн хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэлд тусгасан.

7. Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах талаар:

НДЕГ-ын даргын 2025 оны 01/332 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах журам”-ын хүрээнд:

- Гэрээнд заасны дагуу банкны үйлчилгээний хөлс
- Хаан банкинд 3962.4 мянган төгрөг,
 - Төрийн банкинд 1672.8 мянган төгрөг
 - Голомт банкинд 129.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Гэрээний хэрэгжилтийг хагас жилээр дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж ажилласан.

ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖИЙН ХЭЛТЭС

Тус газрын Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс нь 1 хэлтсийн дарга, газрын 6, 22 сум 1 тосгоны 24 байцаагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгуулан үндсэн чиг үүргийн дагуу Засгийн газрын 2023 оны 362, 438, 439, 448, 450, 2024 оны 10 дугаар тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/69, А/136, А/143, А/177, А/192, А/221, А/376, А/392, А/433, А/441 тушаал, НДҮЗөвлөлийн 2021 оны 09, 2022 оны 04, 04/162 дугаар тогтоол, НДЕГазрын даргын 2023 оны А/8, 10, 11, 20 дугаар тушаал, шийдвэр, зөвлөмжийг мөрдлөг болгон хэрэгжилтийг ханган төрийн үйлчилгээг иргэд даатгуулагчдад хуулийн дагуу хугацаанд нь хүргэн ажиллаж байна.

Нэг. Тэтгэврийн тогтоолт, олголтын талаар:

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр 442, үүнээс мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын дагуу хүүхдийн нөхцлөөр 45, 5.1.5, 5.1.6 дугаар заалтын дагуу малчин нөхцлөөр 105, тахир дутуугийн тэтгэвэр 104, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 40, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 0, цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр 14, нийт 705 иргэний тэтгэврийг шинээр, НДСОТТХуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 142 тэтгэвэр авагч, НДСОТТХуулийн 9 дүгээр зүйл Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу 96 тэтгэвэр авагчдын тэтгэврийг өөрчлөн тус тус тогтоож хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын 221 дүгээр тогтоол “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 22102 тэтгэвэр авагчийн тэтгэврийг 6 хувиар нэмэгдлийг тооцож олгосон.

Тэтгэвэр авагчийн тоо, мөнгөн дүн

Огноо	Тэтгэвэр авагчдын	Зарцуулсан мөнгөн дүн /өссөн дүнгээр/
-------	-------------------	---------------------------------------

	тоо	
2025 он	22102	84627903,5

Тэтгэврийн хөдөлгөөний мэдээ

№	Хөдөлгөөний төрөл	Тэтгэвэр авагчийн тоо
1	Нас барсан тэтгэвэр авагч	169
2	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа сунгасан тэтгэвэр авагч	548
3	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцалсан тэтгэвэр авагч	151
4	Банк өөрчилсөн	280
5	Тэтгэврээ өөрчлүүлэн тогтоолгосон тэтгэвэр авагч	141
	Нийт	4987

2025 оны 6 сарын байдлаар 18376 өндөр насны тэтгэвэр авагчдад 13,854,831,853 төгрөг, 2580 тахир дутуугийн тэтгэвэр авагчдад 1,545,714,389 төгрөг, 938 тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдад 590,016,709 төгрөг 185 өвлөх тэтгэвэр 27,299,266 төгрөг, 1215 тэтгэвэр авагчдийн тэтгэвэрийн нэмэгдэл 62,750,000 төгрөг нийт 21,894 тэтгэвэр авагчид 16,080,612,217 төгрөгийн тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас,

Цэргийн алба хаасны 420 өндөр нас 617,837,536 төгрөг 15 тахир дутуу 12,811,278 төгрөг 28 тэжээгчээ алдсан тэтгэвэр 22,494,523 төгрөг нийт 463 тэтгэвэр авагчдад 653,143,337мянган төгрөгийг улсын төсвөөс,

ҮОМШӨДаатгалын сангаас 50 хөдөлийн чадвар алдалт 45,818,427 төгрөг 11 тэжээгчээ алдсан 8,616,242 төгрөг нийт 61 тэтгэвэр авагчдад 54,432,669 төгрөг нийт 22418 тэтгэвэр авагчдад 16,788,190,224 төгрөгийн тэтгэврийг батлагдсан төсөвт багтаан сар бүрийн 01-ний өдөр бүрэн олгосон.

Банкуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ХААН банкаар 14752 тэтгэвэр авагчид 11,080,982,252 төгрөг, Төрийн банкаар 6097 тэтгэвэр авагчид 4,414,643,480 төгрөг, Голомт банкаар 1569 тэтгэвэр авагчид 1,292,564,492 төгрөг нийт 22418 тэтгэвэр авагчдад 16,788,190,224 төгрөгийн тэтгэврийг батлагдсан төсөвт багтаан сар бүрийн 01-ний өдөр бүрэн олгосон.

Хоёр. Тэтгэмж тогтоолт, олголтын талаар:

2025 оны хагас жилийн байдлаар эмнэлгийн хуудас бүрэн цахимжиж иргэд даатгуулагчдад хүргэх нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан. Тайлант хугацаанд тэтгэмжийн даатгалын сангаас ХЧАТэтгэмжийг 611 даатгуулагчид 130,517,001.00 мянган төгрөг, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 855 даатгуулагчид 2,862,745,988 мянган төгрөг, оршуулгын тэтгэмжийг 295 иргэнд 460,000,000.0 мянган төгрөг нийт 1761 даатгуулагчийн 593,379,747,00 мянган төгрөг, ҮОМШӨД-ын сангаас 25 даатгуулагчид 7,590,036 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 350 даатгуулагчид 1,073,782,988.43 мянган

төгрөгийн тэтгэмжийг баримт бичгийн бүрдүүлэлтийг хуулийн дагуу хангуулж цаг хугацаанд нь олгосон байна.

№	Тэтгэмжийн төрөл	Хүсэлт	Олгосон тоо	Хувь
	Тэтгэмжийн даатгалын сан /нийт/	1768	1761	98,7%
1	ХЧТАТэтгэмж	615	611	99,35%
2	ЖАТэтгэмж	858	855	99,65%
3	Оршуулагын тэтгэмж	295	295	100%
	ҮОМШӨД-ЫН сан /	25	25	100%
1	ХЧТАТэтгэмж	18	8	72,73%
2	Хиймэл эрхтэн портез	0	0	0
3	Рашаан сувилалын зардал	7	4	100%
	АД-ЫН сан /нийт/	364	350	96,15%
1	Ажилгүйдлийн тэтгэмж	364	350	96,15%
	Нийт			99,3%


Хөдөлмөрийн чадвар түр алдсаны мөн жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг бүрэн цахимаар хүлээн авч байгаа бөгөөд тайлант хугацаанд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн 615 хүсэлт хүлээн авснаас 611, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн 858 хүсэлт хүлээн авснаас 855, оршуулгын тэтгэмжийн 259 хүсэлт хүлээн авснаас 295, нийт 1768 хүсэлт хүлээн авч, 1761 хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хуулийн хугацаа дуусаагүй эмнэлгээс, даатгуулагчаас илгээсэн 21, ажилгүйдлийн тэтгэмж 14, нийт 35 буюу 0,5% нь хуулийн хугацаандаа хүлээгдэж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн даатгалын тэтгэмжийн цахим хүсэлт 1625, цаасан баримтаар 532 хүсэлт нийт 2157 баримт бичиг, хүсэлтийг хүлээн авч 2123 хуулийн хугацаанд сар бурийн 10, 25-ны өдрүүдэд батлагдсан төсвийн хүрээнд олгосон байна.

Гурав. ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТАЛААР:

Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрмийн 2.12 дахь заалтыг үндэслэн Зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилуулах саналыг хүргүүлэн НДЕГазрын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/157 дугаар тушаалаар баталсан 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр ЭММЗөвлөлийн үйл ажиллагааг явуулж байна.

2025 оны хагас жилийн байдлаар ЭММЗөвлөл 22 удаа, 1649 цаг хуралдаж зөвлөлийн дарга гишүүд дундажаар 9 цаг хуралдаж 96,5%-ийн ирцтэй оролцсон байна.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 тоот албан даалгаврын 3.4 дахь заалтын хүрээнд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг ЭММЗ-ийн дүрмийн 3.2 дахь заалтыг үндэслэн ЭММЗөвлөлийн хурлаар 1147 хүнийг биечлэн ирүүлэхгүйгээр холбогдох бичиг баримтад үндэслэн хэлэлцүүлж хөдөлмөрийн зохицуулалтын асуудлыг шийдвэрлэн ажилласан. Үүнд:

Шинээр ХЧАлдалтыг тогтоосон 209, цуцалсан 182, сунгасан 692, (хувийг хэвээр сунгасан 582, хувийг нэмэгдүүлэн сунгасан 58, хувийг бууруулан сунгасан 52) буцаасан 64 байна. Мөн тус дүрмийн 3.4-д зааснаар ЭММЗөвлөлийн хурлаар ХЧА-ын хувь хугацаа, шалтгааныг шийдвэрлэх боломжгүй 120 хүнийг биеэр байлцуулан магадлаж хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэж ажилласан. Үүнд: Шинээр тогтоосон 30, сунгасан 44, цуцалсан 18, буцаасан 28 байна.


2025 оны хагас жилийн тайлангийн байдлаар ХЧАлдалтын хувь, хугацаа тогтоолгосон 4569 хүн байгаа бөгөөд шинээр тогтоосон 207, цуцалсан 183, сунгасан 4150, нас барсан 25, шилжиж явсан 4, ирсэн 1, хөдөлмөрийн нөхцөл сольсон 1 байна. Хурлаар хэлэлцэж буй иргэний эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байдлыг эмнэлгийн “E_healt” цахим программаас хяналтын эмчийн үзлэг, оношлогоо шинжилгээ, сэргээн засах эмчилгээ, өдрийн эмчилгээ, хэвтэн эмчлүүлсэн, яаралтай тусламж авсан, сувилалд хамрагдсан, хөнгөлөлттэй эм

авсан зэргийг шүүн баталгаажуулж, дотоодын хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Аймгийн ЭМГ, НДГ, НЭ, ЭММЗөвлөлтэй хамтран ХЧАлдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хийх дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

ЭММЗөвлөлийн мэдээллийн санд бүртгэгдсэн ХЧАлдалтын хувь, хугацаа тогтоосон иргэдийн мэдээллийн сангаас дотрын өвчинөөр түүвэрлэн авч Аймгийн нэгдсэн эмнэлгийн “E-health” цахим программд үндэслэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан байдалд цахимаар хяналт хийж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ аваагүй, эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдаагүй зэрэг байдлыг харгалzan хангалтгүй байсан 41 иргэний амбулаторын карт, холбогдох баримт бичгийг ирүүлэн амбулаторын картны ерөнхий эмх цэгц, үечилсэн дүгнэлт оношийн баталгаажилт болох шинжилгээ оношилгооны бурдлийг хянан шалгаж 15 хүнийг биеэр ирүүлэн ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулан ажилласан. Үүнд:

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын төрөлжсөн мэргэжлийн зүрх судасны эмч Н.Наранчимэг, бөөрний эмч Д.Мөнхцэцэг, хоол боловсруулах эрхтний эмч Ц.Одгэрэл болон ЭМГазрын эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч М.Мөнх-Аюуш, магадлагч эмч З.Эрчмаа нарыг оролцуулан зохион байгууллаа. Тус үнэлгээгээр төрөлжсөн нарийн мэргэжлийн болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарын хяналтанд хамрагдаагүй, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөний дагуу үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээнд хамрагдаагүй 4 ХЧАлдалтын хувь хугацааг ЭММЗөвлөлийн 7.8 дахь заалтыг үндэслэн хурлаар оруулж дахин магадлуулж ХЧАлдалтын хувь, хугацааг цуцалж шийдвэрлүүлсэн.



2025 оны хагас жилийн тайлангийн байдлаар ХЧАлдалтын хувь, хугацаа тогтоолгосон 4569 хүн байгаа ба шинээр тогтоосон 207, цуцалсан 183, сунгасан 4150, нас барсан 25, шилжиж явсан 4, ирсэн 1, хөдөлмөрийн нөхцөл сольсон 1 байна. Мөн Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Хөвсгөл, Увс, Баян-өлгий, Ховд аймгийн ЭММЗөвлөлийн магадлагч эмч, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн 3 эмч, тус бүр 5, нийт 25 эмч, мэргэжилтнүүдийг оролцуулан 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 15 цагт ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу 4 аймаг тус бүр 5 иргэний амбулаторын картны хуулбарыг Хөвсгөл, Ховд аймаг болон Увс, Баян-өлгий аймаг гэж 2 хуваагдан 06 дугаар сарын 12-ны өдөр аймгууддаа хүргүүлсэн. Хөвсгөл аймаг Ховд аймгаас ирүүлсэн 5 иргэний амбулаторын карт, баримт бичгийн материалд үнэлгээ хийхэд 1 иргэний файл нээгдээгүй тул 4 иргэний амбулаторын карт, баримт бичигт үнэлгээ хийж холбогдох материалыг Ховд аймгийн магадлагч эмчид хүргүүлсэн. Үүнд: Ховд аймгаас ирүүлсэн Ц.Болд-эрдэнэ, Л.Энхболд, А.Ташкенбек, Н.Даваасамбуу нарын үнэлгээ болон цаашид дэвшүүлэх саналыг хүргүүлэв. Үүнд:


Хөвсгөл аймгийн дотрын төрөлжсөн мэргэжлийн эмч Ц.Мөнгөнцэцэг дотрын өвчинеэр ХЧА тогтоолгосон 2 иргэн, мэдрэлийн төрөлжсөн мэргэжлийн эмч Θ.Жавхлан мэдрэлийн өвчинеэр ХЧА тогтоолгосон 1 иргэн, гэмтлийн төрөлжсөн мэргэжлийн эмч Б.Чулуунбат гэмтлийн өвчинеэр ХЧА тогтоолгосон 1 иргэний амбулаторын картны хуулбар болон холбогдох баримт бичгийн хуулбарыг үндэслэн хийсэн үнэлгээг танилцуулж, ололттой болон сул талуудыг дүгнэн ярилцаж санал бодлоо солилцсон.

Хэлэлцүүлэг болон ижил мэргэжилтний үнэлгээнээс цаашид дэвшүүлэх санал:

1. Үечилсэн дүгнэлт бичүүлж хэвших
2. Эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах эмчилгээний төлөвлөгөөтэй болгох
3. Өвчний оношийг монголоор дэлгэрэнгүй бичиж байх
4. Давтан үзлэг, шинжилгээг товлож өгөх
5. Анхан шатны болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтыг сайжруулах
6. Хяналтын эмчийн үзлэг хийсэн он сар өдрийг тодорхой бичиж байх шаардлагатай байна.

Ололттой тал нь иргэний амбулаторын карт, баримт бичигт үндэслэсэн үнэлгээнээс харахад оношийн баталгаажилт болох оношилгоо шинжилгээг сайн

хийж хангалттай үнэлэгдэж, харин эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах эмчилгээний төлөвлөгөө, давтан үзлэг, шинжилгээ товлолт хангалтгүй байсан.



НДЕГазрын даргын 01 дугаартай албан даалгаврын 3.5-д заасан чиглэлийн хүрээнд ХЧА бууруулах чиглэлээр сумын Засаг дарга, аймгийн НЭмнэлгийн сэргээн засах болон уламжлалтын тасаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран ажиллаж байна. Үүнд: ХЧА иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах эмчилгээнд хамрагдалтыг сайжруулах чиглэлээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сэргээн засах болон уламжлалт эмчилгээний тасагтай хамтран ажиллаж хамрагдалтыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Үүнд: Нийт 4345 даатгуулагч иргэд хамрагдсанаас ХЧАлдалтын хувь, хугацаа тогтоолгосон 1049 иргэд хамрагдсан байна. (Цахилгаан эмчилгээнд 257 иргэн, Зүү төөнүүр 60, парафин эмчилгээнд 72, иллэг бария засал 370, бумба 70, биеийн тамир эмчилгээнд 50, хөдөлгөөн засал 170 нийт 968 ХЧА иргэд хамрагдсан байна) Мөн аймгийн Эрүүл мэндийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран ажиллаж ХЧАлдалтыг бууруулах чиглэлээр уулзалт, өдөрлөг, сургалт, сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байна.

ЭММЗөвлөлийн магадлагч эмч, ХБИТэргүүн, халамжийн мэргэжилтэн нар сумдын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Холбооны тэргүүн нартай цахимаар уулзалт зохион байгуулж ЭММЗөвлөлийн үйл ажиллагааны талаар болон Эмнэлгийн хуудас бичиж олгоход анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж цаашид ХЧАлдахаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр иргэдэд сургалт сурталчилгаа хийж Сумын Засаг дарга болон ЭМТөвүүдтэй хамтран ажиллах тал дээр анхаарах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд: 23 сумын ХБИТэргүүн, төлөөлөгч нар болох 69 хүн хамрагдсан.



ГБХНХЯМНААС 2025 ОНЫГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЖИЛ БОЛГОН ЗАРЛАСАНТАЙ ХОЛБООТОЙ ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭНД НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ДАРГА, МАГАДЛАГЧ ЭМЧ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН НАР ОРОЛЦОЖ НИЙТ 70 ГАРУЙ ДААТГУУЛАГЧ ИРГЭДЭД НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭГ ДОРООС ХҮРГЭЖ МАГАДЛАГЧ ЭМЧ ЭМНЭЛГИЙН ХУУДАС ОЛГОХ ТАЛААР БОЛОН ЭММЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ ХИЙЖ ИРГЭДИЙН СОНИРХСОН АСУУЛТУУДАД ХАРИУЛЖ НД-ЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЛЭН ГАРЫН АВЛАГА МАТЕРИАЛ ТАРААЖ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ АЖИЛЛАСАН.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв дээр зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш оролцоо”, “Харааны эруул мэнд” сэдэвт өдөрлөгүүдэд оролцож 120 гаруй ХБИргэд даатгуулагчдад ЭММЗөвлөлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хурлын үеэр халамжийн мэргэжилтэн амбулаториор үйлчлүүлж буй иргэдэд ЭММЗ-ийн дүрэм, үйл ажиллагааны талаар ерөнхий мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан.




3.НДЕГазрын даргын 2025.05.06-ны өдрийн 01/1136 тоот албан бичгийн хурээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -Даатгуулагч хүний ХЧА-ын хувь, хугацааг шийдвэрлэхдээ ЭММагадлалтай холбоотой дүрэм, журам, тушаал, шийдвэрийг баримтлан ажиллаж 1147 хүний хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэсэн. ЭММЗ-ийн гишүүдийн хурлын идэвх, оролцоонд дотоодын хяналтыг сайжруулан ажиллаж хурлын тэмдэглэл, цагийн бүртгэлийн судалгааг улирлаар гарган цаг хугацаанд нь ЭММТЗөвлөлд хүргүүлсэн болно.


ХЧА иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх сэргээн засах, ХЧА бууруулах чиглэлээр сумын Засаг дарга, ХБИТ, аймгийн НЭ сэргээн засах болон уламжлалтын тасаг,

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран ажиллаж сэргээн засах эмчилгээнд хамрагдалтыг сайжруулан ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвд



Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах эмчилгээний тасагт



Хөвсгөл аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон иргэдийн судалгааг хүн амын тоо, өвчний ангилал, харьяа сумаар 5 жилээр гарган дүн шинжилгээ хийж ХЧАлдсан иргэнийг эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах эмчилгээнд хамруулах тал дээр төлөвлөгөө гарган аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран ажиллаж байна. Дээрх судалгаанд үндэслэн ЭММЗөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тоон тайланд хийсэн дүгнэлтийн талаар Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт

танилцуулан ЭММЗөвлөлийн хамтарсан уулзалт зохион байгууллаа. Үүнд: ХЧА хүний тоогоор Улсын дунджаас дээгүүр байгаа эхний 5 байрын сумын Эрүүл мэндийн төв, Засаг дарга нартай хамтран ХЧА иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх сэргээн засах эмчилгээний хамралтыг эрчимжүүлж ажиллахад аймгийн Засаг дарга, ИТХурлын дарга нарыг нараас чиглэл заавар өгөх, ЭММЗөвлөлийн хурлын байр, тавилга эд хогшил тохижилтын талаар дэмжлэг үзүүлж ажиллахаар болсон.



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд ЭММЗөвлөлийн 2024 оны байдлаар ХЧА тогтоолгосон иргэдийн судалгааг сумаар нь хүн амын тоонд харьцуулан гаргаж олон нийтийн цахим сүлжээнд байршуулж даатгуулагч, иргэдэд мэдээллийг нээлттэй, ил тод хүргэх арга хэмжээг авч ажиллалаа.

3. НДЕГ-ын даргын 2025.05.19-ний өдрийн 01/1244 тоот албан бичгийн хүрээнд:


ХЧА тогтоолгосон иргэдийн зонхилон шалтгаан болж буй өвчлөлөөр сумаар нь гарган аймгийн Засаг даргад танилцуулан олон нийтийн сүлжээнд байршуулсан. Сумын байцаагч нарт НДГазрын даргын албан даалгаврын хүрээнд төрийн болон албаны нууцын тухай, байгууллагын нууцын тухай цахимаар сургалт мэдээлэл хийж ХЧА магадлан шийдвэрлэхтэй холбоотой санал, гомдол мэдээллийг тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж, холбогдох чиглэл зөвлөмжийг өгч ажилласан.




4. 2025 оны Чиглэл хүргүүлэх тухай 09/12 тоот албан бичгийн хурээнд


ЭММЗөвлөлийн дарга гишүүдийн ёс зүй авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн сургалтанд хамрагдаж, харилцаа хандлагыг сайжруулан хуулийн хурээнд ажиллаж байна.





Мөн ЭММЗөвлөлийн бүх гишүүдтэй хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн нууцын гэрээ байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хариуцлагыг сайжруулах талаар хамтарч ажиллах тухай “БАТЛАМЖ” гардуулан үүрэг хариуцлагыг өндөржүүлж ХЧАлдалтыг магадлан шийдвэрлэхтэй холбоотой санал, гомдол мэдээллийг тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх чиглэлийг өгсөн.





Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Р.Төрбулагийн Авлигын гэмт хэрэг ба авлигын хор хөнөөл сэдэвт сургалтад магадлагч эмч нарын сургалтын үеэр танхимаар хамрагдсан.

ЭММТЗөвлөлөөс зохион байгуулсан “Эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж олгоход анхаарах асуудал” сэдэвт сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт Хөвсгөл аймгийн 18 сумын 48 эмч мэргэжилтэн, хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагын 7 нийт 55 эмч, мэргэжилтэн цахимаар, аймгийн НЭ-ийн төрөлжсөн мэргэжлийн 8 ЭМГазрын 5, Өрхийн ЭМТөвийн 12 нийт 26 эмч, мэргэжилтэн танхимаар нийт 81 эмч мэргэжилтэн оролцож санал бодлоо солилцон мэргэжил арга зүйн зөвлөмж, зөвлөгөө авч үйл ажиллагаандaa хэрэгжүүлэн ажилласан.

Мөн ЭММЗөвлөлийн үйл ажиллагаа, эмнэлгийн хуудас бичилт, олголттой холбоотой тушаал шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар сургалт явуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүнд: Далай элбэрэлт, Энэрэл, Энх-үйлс ӨЭМТөвийн нийт 45 эмч мэргэжилтэн танхимаар хамрагдсан.



2025 оны хагас жилийн байдлаар жирэмсэн болон амаржсаны 1494, хөдөлмөрийн чадвар түр алдсаны 979 эмнэлгийн хуудсыг хянан баталгаажуулж ажиллаа .

2025 оны хагас жилийн байдлаар Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой 2 иргэний өргөдөл, гомдолын хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэж, албан бичгээр хүргүүлж ажилласан.

ДАРГА ТАНИЛЦСАН:
П.ЮМЖИРДУЛАМ
ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА П.МАЙНБАЯР